



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 20 өдөр

Дугаар А/37

Хужирт сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Эрэн хайх, аврах бүлгийн аврах ажиллагааны УАЗ фургон машины сэлбэгт 1,550,000 (нэг сая таван зуун тавин мянга) төгрөгийг хавсралтаар зарцуулсугай.

2. Дээрх хөрөнгийг Засаг даргын нөөц сангаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын Нягтлан бодогч (Г.Оюунмандах)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ